



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/227

Улаанбаатар хот

Усанд сэлэлтийн тэмцээний
заавар батлах тухай

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын дунд зохион байгуулагддаг "Онцгой байдлын байгууллагын усанд сэлэлтийн тэмцээн зохион байгуулах заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврын дагуу алба хаагчдыг бэлтгэх, бэлтгэл сургууль хийх боломжоор хангахыг Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга (хурандаа Б.Үнэнбаатар)-д даалгасугай.

ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

142411827

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн
127 дугаар тушаалын хавсралт



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН УСАНД СЭЛЭЛТИЙН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын усчин-аврагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, олон улсын усчин-аврагчдын тэмцээнд баг тамирчдыг бэлтгэх, алба хаагчдыг усан сэлэлтийн спортоор хичээллүүлэх, эрүүл мэнд болон бие бялдрыг хөгжүүлэхэд оршино.

1.2. Заавар нь Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн онцгой байдлын анги, салбар, нэгжид хамаарна.

Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, зай, төрөл

2.1. Усан сэлэлтийн тэмцээн нь дараах төрөлтэй байна. Үүнд:

2.1.1. мандлын усанд сэлэлт

2.1.2. 50 м хөл сэлүүртэй /ласт/ уртын шумбалт

2.1.3. 4x50 м буухиа сэлэлт

2.2. Тэмцээний зохион байгуулалт

2.2.1. Ганцаарчилсан төрөл:

Тус төрөлд оролцох тамирчдын тоог хязгаарлахгүй.

Эмэгтэй

- Мэлхий сэлэлт 50 м.

- Өврөөр даллах сэлэлт 50 м.

Эрэгтэй

- Мэлхий сэлэлт 50 м.

- Өврөөр даллах сэлэлт 50 м.

2.2.2. Хөл сэлүүртэй /ласт/ 50 м зайд усан доогуур шумбах төрөл:

Баг тус бүрээс 1 тамирчин 50 м зайд гарааны тавцангаас хөл сэлүүртэй /ласт/ үсэрч усан доогуур шумбалт хийж зайг дуусгана. Хөл сэлүүрийн /ласт/ урт /60 см/-ээс ихгүй байна. Бариганаас гараа хүртэлх зайг цагаар хэмжинэ.

2.2.3. Буухиа сэлэлтийн төрөл:

4x50 м буухиа сэлэлтэд 3 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчин оролцоно.

- 1 дугаар алба хаагчийн гүйцэтгэх даалгавар:

Гарааны тавцангаас шүглийн дуугаар өврөөр даллаж 25 м сэлээд усан дотор шалан дээр тавьсан хиймэл хүнийг нэг гартаа барин нөгөө гараар 25 м зайг сэлж дуусгана.

- 2 дугаар алба хаагчийн гүйцэтгэх даалгавар:

Гарааны тавцангаас хөл сэлүүртэй /ласт/ 25 м шумбаж усан сангийн эрэг дээр тавьсан хиймэл хүнийг өөрийн биед байх олсонд бэхэлж, өврөөр даллах сэлэлтээр зайг дуусгана.

- 3 дугаар алба хаагчийн гүйцэтгэх даалгавар:

Гарааны тавцангаас өврөөр даллах сэлэлтээр 25 м зайд эргэлт хийж буцаж 10 м зайд сэлэн хажуугийн шүүгчийн дохиогоор зогсоход багийн нэг гишүүн гарааны тавцангаас эмэгтэй тамирчин руу олстой аврах цагаригийг шидэж эмэгтэй тамирчныг татаж барианд хүргэнэ.

- 4 дүгээр алба хаагчийн гүйцэтгэх даалгавар:

Гарааны тавцан дээрээс хөл сэлүүртэй /ласт/ үсрэлтийг хийж өврөөр даллах сэлэлтээр сэлж өөрийн биед бэхэлсэн 5 м-ээс уртгүй олсоор хиймэл хүнийг чирч 50 м зайд дуусгана. Үсрэлтийг хийх үед хиймэл хүнийг усан дотор гарааны тавцангийн дор байрлуулсан байна.

Гурав. Тэмцээнд оролцогчдод тавигдах шаардлага.

3.1.Тэмцээнд оролцогч нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар томилогдсон цэргийн болон энгийн алба хаагч байна.

3.2.Тэмцээнд оролцох багууд усанд сэлэлтийн зориулалтын өмсгөл, малгай, шилтэй байна.

3.3.Тэмцээнд оролцох алба хаагчид эрүүл мэндийн болон аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцан гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

3.4.Эрэгтэй алба хаагчид цагаан хорхой, сүрьеэ, эмэгтэй алба хаагчид цагаан хорхой, сүрьеэ, мазокын шинжилгээг өгсөн байна.

Дөрөв. Тэмцээний шүүх

4.1.Ганцаарчилсан сэлэлтийн төрөл, 50 м уртын шумбалт, 4x50 м багийн буухиа сэлэлт тус бүрийг минут, секунд, долиор хэмжинэ.

- Багийн буухианд оролцох 4 тамирчин ганцаарчилсан болон 50 м уртын шумбалтын төрөлд оролцож болно.

- Ганцаарчилсан болон 50 м уртын шумбалтын төрөлд оролцох алба хаагчдыг хязгаарлахгүй нээлттэй явуулна.

4.2.Багийн оноо тэнцсэн тохиолдолд медалийн чанарыг харах ба медалийн чанар, оноо тэнцсэн тохиолдолд буухиа тэмцээний сугалааны дарааллаар шийднэ.

4.3.Тэмцээнд оролцож байгаа баг тамирчид аврах хантааз ашиглахгүйгээр сэлэлтийг гүйцэтгэнэ.

Тав. Тэмцээний хэрэгсэл


а. Аврах цагариг



б. Хиймэл хүн



в. Хөлийн ласт



Зургаа. Бусад

6.1. Зааврын дагуу баг тамирчдаа бэлтгэх, бэлтгэл хийх нөхцөл боломжоор хангах, тэмцээнд шаардлагатай (хөлийн ласт, аврах цагариг, хиймэл хүн) хэрэгслийг анги, салбар, нэгж хариуцна.

---oOo---